



МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 376 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын баталсан “Допингийн эсрэг үндэсний дүрэм”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг Монголын Үндэсний Олимпын хороо, Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хороонд даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын алба (Э.Тэмүүжин)-д үүрэг болгосугай.

Монгол Улсын сайд, Олимп,  
нийтийн биеийн тамир, спортын  
Үндэсний хорооны дарга



Б.БАТ-ЭРДЭНЭ

000512

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ий өдрийн 04 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ДОПИНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ДҮРЭМ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хийгдэх ажил	Гүйцэтгэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа /улирал/
1	Допингийн эсрэг үндэсний дүрмийг эхний ээлжинд олимпын төрлийн болон төрөөс санхүүгийн дэмжлэг авч буй Спортын холбоодоор хүлээн зөвшөөрүүлсэн гарын үсэг зуруулах үйл ажиллагаа зохион байгуулах	<p>Спортын холбоодыг ингэхдээ холбоодын ерөнхийлөгч, ерөнхий нарийн бичгийн дарга нарыг оролцуулах</p> <p>Спортын холбоодын удирдлагуудад дүрмийг танилцуулах, гарын үсэг зурж, баталгаажуулах</p>	МҮДЭБ	ОНБТСҮХ МҮОХ, БТСҮХ Спортын холбоод	II улирал
2	Допингийн эсрэг Үндэсний зөвлөл /плаформ/ байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах	<p>Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагад дүрмийг тайлбарлах, оролцоо, гүйцэтгэх үүрэг, хариуцлага тодорхой болгох</p> <p>Үндэсний зөвлөлд орох байгууллагууд руу албан бичиг явуулж, зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах албан тушаалтныг томилуулах, мэдээллийн сан үүсгэх</p> <p>Үндэсний зөвлөлийн анхны хурлыг зохион байгуулах</p> <p>Үндэсний зөвлөлийн ажиллах журмын төсөл, ажлын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг боловсруулж, хуралдаанаар хэлэлцэн батлах</p>	ОНБТСҮХ	БТСҮХ МҮОХ МҮДЭБ	II улирал

3	Монголын үндэсний допингийн эсрэг байгуулагатай хамтран ажиллах ба санхүүгийн гэрээ байгуулах	Биеийн тамир, спортын улсын хороо болон Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын хамтын ажиллагаа, санхүүжилт, талуудын үүрэг, хариуцлагын тухай гэрээний төсөл боловсруулах, ажлын урьдчилсан тооцоо гаргах, хэлэлцэн тохирох, төлөвлөгөө батлах, гэрээ байгуулах	ОНБТСҮХ МҮДЭБ	ОНБТСҮХ	I-IV улирал
4	Хэрэг хянан шийдвэрлэх комисс байгуулах	Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага нь дэргэдээ Хэрэг хянан шийдвэрлэх комисс шинэчлэн байгуулах, үйл ажиллагааны дотоод журам, ажлын төлөвлөгөө боловсруулан батлах	ОНБТСҮХ	МҮОХ, МҮДЭБ Бусад мэргэжлийн байгууллагууд	II улирал
5	Эмчилгээний зорилгоор чөлөөлөх комисс байгуулах	Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага нь дэргэдээ Эмчилгээний зорилгоор чөлөөлөх комисс шинэчлэн байгуулах, үйл ажиллагааны дотоод журам, ажлын төлөвлөгөө боловсруулан батлах	МҮДЭБ	МҮДЭБ	I-IV улирал
6	Допингийн эсрэг сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Үндэсний шигшээ баг, спортын холбоод, үндэсний спортын холбоод, өсвөрийн шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчдад сургалт зохион байгуулах Спортын сэтгүүлчдийн дунд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах Сургалтын материал бэлтгэн тараах	ОНБТСҮХ МҮДЭБ	ОНБТСҮХ БТСҮХ Хэвлэл мэдээллийн байгууллагууд Цахим мэдээ хөгжүүлэгч нар	I-IV улирал
7	Допингийн эсрэг үр дүнгийн удирдлагын ажиллагаа зохион байгуулах	Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага нь тамирчдаас шинжилгээ авах, дээж цуглуулах, лабораторид хүргүүлэх, шинжилгээний хариу ирэхэд олон нийтэд хүргэх, шударгаар хянан шийдвэрлэх бүхий л үйл ажиллагааг зохион байгуулах	МҮДЭБ	ОНБТСҮХ МҮДЭБ	I-IV улирал

8	Допингийн шинжилгээ, мөрдөн шалгалтын ажиллагаа зохион байгуулах	Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага нь холбогдох байгууллагуудтай хамтран мөрдөн шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх	МҮДЭБ	ОНБТСҮХ МҮДЭБ	I-IV улирал
9	Гэрээний гүйцэтгэл, үр дүнгийн хурал хийх, аудит хийх, гэрээгээ дүгнэх	Биеийн тамир, спортын улсын хороо болон Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын хамтын ажиллагаа, санхүүжилт, талуудын үүрэг, хариуцлагын тухай гэрээнд аудит хийж, гэрээ дүгнэх	Үндэсний аудитын газар, Хөндлөнгийн хараат бус аудит	ОНБТСҮХ МҮДЭБ	II улирал

---000---